



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/289

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтууд тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн”-ний хүрээнд Засаг даргын урилгаар газар тариалангийн бүс нутгуудад үр тариа болон тэжээлийн ургамлын тариалалтын талаар зөвлөгөө, сургалт зохион байгуулсан “Монголын царгас үржүүлэгчдийн холбоо”-ны ерөнхийлөгч гавъяат агрономч Ц.Ширчинжавын замын зардал, зөвлөх багшийн төлбөрт 1 740 100 төгрөг, Засаг дарга Баруун гурван сумдад ажилласан зардалд 526 000 төгрөг, Тайвань дах “Монгол соёлын нийгэмлэг” ТББ-н шугамаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвд эмнэлгийн тоног төхөөрөмж хандивласан Тайваны Соёлын яамны зөвлөх Баатар Хай, Тайпэйн Худалдаа, эдийн засгийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газрын сайд Хуан Куо Рун тэргүүтэй төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын зардалд 280 000 төгрөг, аймгийн талаар нэвтрүүлэг бэлтгэсэн сэтгүүлчд болон ногоон байгууламжийг тарьж ургуулах, арчлалт хамгаалалтыг хийх агрономч, орчуулагчийн ажилласан зардалд 685 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 3 231 100 төгрөг /Гурван сая хоёр зуун гучин нэгэн мянга нэг зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/289 Ch
02 01426